

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ АСУУДЛААР
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2017 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Байнгын хороо 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Отгонбилэгийн Содбилэгийг нэр дэвшүүлэх тухай Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн саналыг хэлэлцлээ.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд батлан хамгаалах бодлого, багц хуулиуд батлагдан хэрэгжиж байгаа. Цаашид Орон нутгийн хамгаалалтын тухай, Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд, батлан хамгаалах салбарын төсөв, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжиж ажиллахыг, Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү Улсын Их Хурлын гишүүн байнгын болон дэд хороонд хамрагдах хуулийн заалттай. Дэд хороонд хамрагдах хүсэлтээ гаргасан байгаа, түүнийг даруй шийдвэрлэхэд анхаарч ажиллах саналуудыг тус тус гаргасан болно.


Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Отгонбилэгийн Содбилэгийг нэр дэвшүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН
ДАРГАЛАГЧ**



Ц.МӨНХ-ОРГИЛ